

АРДЧИЛСАН НАМ

Гурванбулаг сумын  
АН-ын хорооны тэргүүлэгчдийн  
хурлаар хэлэлцэж батлав.  
2020.оны 8-р сарын 14-ны өдөр

## БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

**Хөтөлбөрийн уриа: Хүн бүрд орлого, өрх бүрд өсөлт**

**Нэг. Хүртээмжтэй эдийн засаг, өсөлтийг хангах бодлого.**

1.1. Сумын ДНБ-ний үйлдвэрлэлийг жил бүр өсгөж, нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээг “ Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого”ын баримт бичигт заасан хэмжээнд хүргэх.

1.2. Сумандаа ахуйн үйлчилгээ, гар урлал, оёдлын цех, үйлдвэрийг байгуулж, үйл ажиллагааг дэмжинэ.

1.3. “Баянхонгорт үйлдвэрлэв” сүлжээ дэлгүүрийг сумандаа байгуулж орон нутгийн жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

1.4. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны болон эцсийн бүтээгдэхүүн боловсруулах ЖДҮ байгуулахыг тухайн сангийн хөрөнгөөр дэмжинэ.

1.5. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ биржийн худалдаа, цахим худалдаагаар борлуулах хэлбэрт шилжиж, зах зээлийн үнийн эрсдлээс хамгаалж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

### **Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө**


#### **2.1. Боловсрол**

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ. Багшийн хангамжийг нэмэгдүүлнэ.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлнэ.

2.1.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд ААН, байгууллагуудыг дэмжинэ.

2.1.4. Сургууль цэцэрлэг, соёлын төвийг шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, барилгын засвараар үе шаттай хангаж, сургууль, цэцэрлэгийн удирдлагын чадавхийг сайжруулна.

  
000000001

2.1.5. Анги дэвших төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангиа 60-аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгуулсан багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.1.6. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтад малчдын хүүхдийг хамруулна.

2.1.7. Урлаг, соёлын биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлуулан өвлүүлэхийг бодлогоор дэмжинэ.

## **2.2. Эрүүл мэнд**

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадвар сайтай хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэх

2.2.3. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, сургалтад хамруулах, ур чадварын нэмэгдэл олгох, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр эн тэргүүнд хангана.

2.2.5. Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.6. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

## **2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгаалал**

2.3.1. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төв суурингийн өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.3. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

2.3.4. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвх санаачилга, боломжийг дэмжиж, хөгжүүлнэ.

2.4.5. Залуучуудын хөгжлийн дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тэднийг бүх талаар дэмжиж ажиллана.

The bottom right corner of the document features several handwritten signatures in black ink. Below the signatures is a red circular stamp containing the number "000000002".

## **Гурав. Хөдөө аж ахуй, Байгаль орчин**

### **3.1. Мал аж ахуй**

3.1.1. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг баримтална.

3:1:2. Сүү цагаан идээг уламжлалт болон орчин үеийн технологиор боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулан хөгжүүлнэ.

3:1:3. Сумын хонин сүрэгт Баяд үүлдрийг сайжруулагчаар ашиглаж, амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

3:1:4. Сумын ямаан сүрэгт "Бөмбөгөрийн улаан" ямааг сайжруулагчаар ашиглаж, нэгжээс авах ноолуурын гарц, чанарыг тогтвортой түвшинд байлгах, сайжруулах.

3:1:5. "Малын эрсдэлийн сан"-г байгуулан, бэлчээр хамгаалах, бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах, хөв цөөрөм байгуулах, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг байх орчинг бүрдүүлнэ.

3:1:6. Малын эрүүл мэндийг хамгаалахад анхаарч, малын эмч нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, мал эрүүлжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.

### **3.2. Газар тариалан:**

3.2.1. Тохиромжтой газруудад хадлангийн талбай бий болгож, бүрэн ашигладаг болох.

3.2.2. Тохиромжтой газруудад 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх.

3.2.3. Жил бүр мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын үеийн 7 хоногт шаардлагатай хадлан тэжээлийг бэлтгэнэ.

3.2.4. Төмс, хүнсний ногооны стандарт зоорь барьж ашиглах асуудлыг төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ.

### **3.3. Тогтвортой байгаль орчин**

3.3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлнэ.

3.3.2. Хөдөөгийн эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.3. Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландфилын аргаар дарна.

A handwritten signature in black ink is written over a red circular stamp. The stamp contains the number 000000003.

3.3.4. Гол горхи,булаг шандны эхийг хамгаалах, ойжуулах, модлог ургамлуудыг тариалах.

3.3.5. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.

## **Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал**

### **4.1.Сайн засаглал**

4.1.1.Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2.Төрийн байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан,мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог дагаж мөрдөнө.

4.1.3. Иргэдээс төрийн алба, албан тушаалтантай холбоотой авлига,хээл хахууль, ашиг сонирхлын зөрчлийн талаар гаргасан мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

### **4.2.Төсөв санхүү**

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2.Төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, сумын төсвийн чадавхийг нэмэгдүүлнэ.

4.2.3. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

### **4.3. сум багийн хөгжил.**


4.3.1.Сумандаа дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 30-50 айлын хувийн хаус хороолол, ашиглалтад оруулна.

4.3.2. Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод,хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулна.

4.3.3.Сум, багийн төвүүдийг шинэчлэх төслийг сэргээж, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### **4.4. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах**

4.4.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, төв суурин газар, тодорхой цэгүүдийг телекамерийн хяналтад авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.


  
000000004

4.4.2. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулж “Архигүй Гурванбулагчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.4.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй сум” болохыг зорино.



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН АРДЧИЛСАН  
НАМ**

  
  
 0000000000